



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

┌ Журам шинэчлэн батлах тухай ┐

Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн тус тус үндэслэн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. “Эрдэм шинжилгээний байгууллага, ажилтанд грант олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Эрдэмтэн нарийн бичгийн дарга (Б.Авид), Тэргүүлэгчдийн газрын дарга (А.Баярбаатар) нарт даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ


ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, АКАДЕМИЧ



Д.РЭГДЭЛ

Б.АВИД

Шинжлэх ухааны Академийн
Тэргүүлэгчдийн хурлын 2024
оны 04 дугаар сарын 01-ны
өдрийн 04 дугаар тогтоолын
хавсралт



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА, АЖИЛТАНД ГРАНТ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Грант нь "Шинжлэх ухаан, технологийн тухай" Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх заалтын дагуу суурь болон хавсарга судалгааны ажлыг санхүүжүүлэх нэг хэлбэр юм.

Тайлбар: "Грант" гэж "Шинжлэх ухаан, технологийн тухай" Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлийн 1.6-д заасныг ойлгоно.
2. Грантаар олгох санхүүжилтийн хэмжээг батлагдсан төсөвтэй уялдуулан ШУА-ийн Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.
3. Төслийн захиалагч (цаашид "Захиалагч" гэх) нь ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар байна.
4. Грантыг нийгмийн бодит хэрэглээ болгох боломжтой суурь болон хавсарга судалгааны ажлын завсрын болон эцсийн үр дүнд зайлшгүй шаардлагатай нэмэлт судалгаа, тооцоо, үндэслэл, боловсруулалт хийх, төрийн бодлого боловсруулахад шинжлэх ухааны үндэслэл болохуйц судалгааны үр дүн, олон нийтийн оюуны хэрэгцээг хангахуйц ном бүтээл хэвлэн нийтлүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний байгууллага, ажилтанд нэг жил хүртэлх хугацаагаар олгож байна.
5. Грантаар санхүүжүүлэх төслийн удирдагч нь доктор болон түүнээс дээш зэрэгтэй байна.
6. Грантаар санхүүжүүлэх ажлыг гүйцэтгэхдээ магистрант, докторант оролцуулж болно.
7. Нэг судалгааны ажилд олгох грантын дээд хэмжээ нь 10 сая төгрөг байна.
8. Грантын зохих хувийг судалгааны ажилд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бодис болон бусад материал, ном, программ хангамж худалдан авахад зарцуулж болох бөгөөд гадаад томилолт, сургалтын зардалд зориулж болохгүй.
9. Грантын 30 хүртэлх хувийг гүйцэтгэгчийн цалинд зарцуулж болно.

Хоёр. Грантаар санхүүжүүлэх судалгааны үр дүнг сонгох, баталгаажуулах

1. Грантаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний санал хүлээн авах зарыг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор нийтэд нээлттэй мэдээлнэ.
2. Грантаар санхүүжүүлэх ажлын саналыг эрдэм шинжилгээний байгууллага гаргана.

3. Тухайн эрдэм шинжилгээний байгууллага уг асуудлыг эрдмийн зөвлөлийн хурлаараа хэлэлцэн, гаргасан шийдвэрээ дараах бичиг баримтын хамт Тэргүүлэгчдийн газарт ирүүлнэ.
4. Үүнд:
 - *Эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, тогтоол;*
 - *Грантаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний үр дүнгийн тодорхойлолт;*
 - *Грантаар хэрэгжүүлэх ажлын календарчилсан төлөвлөгөө, зардлын задаргаа;*
 - *Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд материал, ном зохиол программ хангамжийг гадаадаас худалдан авах бол авах улс орон, байгууллагын нэр хаяг, үнэ, тээврийн зардал, гааль НӨАТ-ын татвар зэргийг тусгасан хүснэгт;*
 - *Шаардлагатай тохиолдолд уг ажлыг үйлдвэр практикт нэвтрүүлснээр гарах үр дүн, өгөөж;*
 - *Грантаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний удирдагч, гүйцэтгэх ажилтны тодорхойлолт, тухайн сэдэвтэй холбогдох бүтээлийн жагсаалт;*
 - *Үр дүнг хүлээн авах байгууллагын санал;*
5. Бүрдэл дутуу, шаардлага хангаагүй саналыг сонгон шалгаруулалтад оруулахгүй.
6. Грантаар санхүүжүүлэх төсөл сонгон шалгаруулах комисс (цаашид "Комисс" гэх)-г ШУА-ийн Эрдэмтэн нарийн бичгийн даргаар ахлуулсан 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр ШУА-ийн ерөнхийлөгчийн тушаалаар байгуулна.
7. Комисс грантаар санхүүжүүлэхээр ирүүлсэн төслийн саналд мэргэжлийн шинжээчийн багаар дүгнэлт гаргуулна. Шинжээчийн баг нь шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталсан аргачлалын дагуу ажиллана.
8. Комисс тухайн салбарын бага чуулган, төрөлжсөн Академийн саналыг харгалзан шинжээчийн багийг томилно.
9. Комисс нь шинжээчийн багийн олонхын саналаар дэмжигдсэн судалгааны ажлын саналыг хэлэлцэн дүгнэж, дүгнэлтээ 5 дугаар сарын 15-ны дотор ШУА-ийн Ерөнхийлөгчид танилцуулна.
10. Төслийн нэгдсэн саналыг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж, тогтоол гаргана.
11. Грантаар санхүүжүүлэх ажлыг гүйцэтгэх гэрээг ШУА-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, гүйцэтгэх эрдэм шинжилгээний байгууллагын захирал, төслийн эрдэм шинжилгээний удирдагч нар байгуулж, ШУА-ийн Ерөнхийлөгч баталгаажуулна.
12. Төслийг зарлах, сонгон шалгаруулах, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнтэй нь танилцах, шинжээч ажиллуулахтай холбогдон гарах зардлыг Тэргүүлэгчдийн газар хариуцна.

Гурав. Үр дүн, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах

1. ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын холбогдох хэлтсүүд төслийн хэрэгжилтийн явц, хугацаа, үр дүн, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн байдал, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. Хяналтын зардал нь төслийн нийт зардлын нэг хувиас хэтрэхгүй байна.

2. Шаардлагатай тохиолдолд төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих хараат бус шинжээчийн баг ажиллуулж болно.
3. Захиалагч төслийн үр дүнг гүйцэтгэгчээс хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан шинжээчээр хянан магадалгаа хийлгэнэ.
4. Гэрээнд заасан шаардлагыг хангаагүй үндэслэлээр захиалагч төслийн эцсийн үр дүнг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд уг ажлыг дахин гүйцэтгүүлэх, эсхүл санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх арга хэмжээг авна.
5. Гүйцэтгэгч төслийн үр дүнг "ШУА-ийн грант минисимпозиум" эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсан байна.
6. Гүйцэтгэгч төслийн үр дүнг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан "Шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг үнэлж, хүлээн авсан акт"-ын үлгэрчилсэн загварын дагуу 3 хувь үйлдэж захиалагч, гүйцэтгэгч байгууллага тус бүрд нэг хувийг хадгалуулна.
7. Төслийн үр дүнгийн тайлан болон санхүүгийн тайланг Монгол Улсын холбогдох стандартын дагуу бичиж, төсөл дууссанаас хойш 2 сарын дотор цахим болон хэвлэмэл хэлбэрээр ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт хүлээлгэн өгнө.
8. Хэрэгжилтийн явцад бий болсон оюуны өмчийг өмчлөх, эзэмших асуудлыг Инновацын тухай хуулийн 27.1-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ.
9. Грантын санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулаагүй, эсвэл энэхүү журмын 3 дугаар зүйлийн 4-д заасан нөхцөл үүсвэл хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--- ооОоо ---